



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/739

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны "Хүүхдийн хөгжил, хамгааллын жил" болгон зарлах тухай 06/05 дугаар тогтоол, "Аймгийн 2018 оны төсөв батлах тухай" 06/08 дугаар тогтоолын 3.2. дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хүүхдийн хөгжил, хамгааллын жил"-ийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлуудад шаардагдах 6814050 (зургаан сая найман зуун арван дөрвөн мянга тавь) төгрөгийн зардлыг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101610

D:My Doc. Zahiramj. Zasag darga



Аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 11 -ны өдрийн 11/173 дугаар захирамжийн хавсралт

“ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД  
ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, БУСАД АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Арга хэмжээ	Зардлын дүн (төгрөгөөр)
1	Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн сурагчдын хэрэгжүүлсэн “Ном бидний анд” төсөл	3011850
2	Арвайхээр сумын 3 дугаар цэцэрлэгийн гаднах блокон хашаа барих зардал	744500
3	Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Уянга, Богд сумдад зорилтот жилийн нээлтийн үйл ажиллагаа, зарим сумдад сургалт зохион байгуулсан ажлын хэсгийн томилолт, шатахууны зардал	721800
4	Зүүн хойд Азийн орнуудын NEAR-ын олон улсын хуралд оролцсон төлөөлөгчдөд бэлэг дурсгал өгөх, хүлээн авалтын зардал	375900
5	Д аминдэмийн дутлын тандалтын шинжилгээний урвалж бодис худалдан авсан зардал	1960000
	Нийт	6814050 (зургаан сая найман зуун арван дөрвөн мянга тавь) төгрөг